

## ТУСЛАХ МАЛЧИН АЖЛУУЛАХ ГЭРЭЭ

/Иргэд хооронд байгуулах хөдөлмөрийн гэрээ/

20.. оны .... дугаар  
сарын ....-ны өдөр

№ \_\_\_\_\_

Улаанбаатар хот

### НЭГ. ГЭРЭЭНИЙ ТАЛУУД

- 1.1. Туслах малчин ажлуулах гэрээ / цаашид "Гэрээ "гэх /-г Монгол Улсын иргэн .....-ны ..... /РД: ,...../ цаашид "Ажил олгогч" гэх /, нөгөө талаас: Монгол Улсын иргэн, .....-ны ..... /РД: ..... / цаашид "Малчин" гэх / , /хамтад нь "Талууд" гэх/ нар нь Монгол Улсын "Иргэний хууль", Хөдөлмөрийн тухай хуулийн 69-71-р зүйл, талуудын хүсэл сонирхлыг үндэслэн малчин нь тохиролцсон ажил, үйлчилгээг гүйцэтгэх, ажил олгогч нь гэрээний дагуу хөлс төлөхтэй холбогдох харилцааг зохицуулах зорилгоор, дор дурдсан нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

### ХОЁР. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 2.1. Гүйцэтгэх ажил үүрэг: Үндсэн малчин буюу ажил олгогчийн өмчлөлийн ..... тооны бог /хонь - ....., ямаа- ..../ болон ..... тооны бод /адуу- ..., үхэр- ... тэмээ - ..../ малыг үндсэн малчин буюу ажил олгогчийн дэргэд амьдарч, түүний удирдлага, хяналтын доор зөв зохистой маллаж, ашиг шим(ноос, ноолуур, мах, төл)-ийг хүлээлгэн өгнө.
- 2.2. Ажил үүргээ гүйцэтгэх байршил: Монгол улс, ..... аймаг, ..... сумын ..... баг, ..... газарт байрлаж ажиллана. Отор нүүдэл, малын бэлчээр өөрчлөсөн бол энэ зүйлд заагдсан байршил өөрчлөгдөж болно.
- 2.3. Ажлын цалин хөлс: Нэг сарын ажлын хөлс ..... төгрөг байна.
- 2.4. Ажлын хөлсийг сар бүрийн .....-ны дотор малчины ..... банкны төгрөгийн ..... тоот дансанд олгоно. Малчин зөвшөөрсөн бол түүний цалин хөлсний 30-аас илүүгүй хувийг мөнгөн бус хэлбэрээр олгож болно.
- 2.5. Гэрээт ажлыг 20 .. оны .... дугаар сарын ....ны өдрөөс 20.. оны .... дүгээр сарын ....ны өдрийг хүртэл ..... (сар/ жил)-ийн хугацаанд хийж гүйцэтгэнэ.
- 2.6. ....

### ГУРАВ. АЖИЛ ОЛГОГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Малчиныг гэрээгээр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, зааварчлах, үүрэг даалгавар өгөх, биелэлтийг хангуулах, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэхийг шаардах бүрэн эрхтэй.
- 3.2. Малчинд ажлын хөлсийг гэрээнд заасан хугацаанд, тохирсон хэлбэр, хэмжээгээр саадгүй төлөх үүрэгтэй.
- 3.3. Мал маллахад шаардлагатай урсгал зардал (хашаа, хороо, малын тэжээл, отор нүүдэл хийх машин, техник, бинзен тос, гэр сууц, хоол хүнс, ахуйн хэрэглээний бараа гэх мэт)-ийг хариуцах үүрэгтэй.
- 3.4. ....

### ДӨРӨВ. МАЛЧИНЫ ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1. Малыг өсгөх, ашиг шимийг нь нэмэгдүүлэхтэй холбогдсон аливаа асуудал буюу санаачлга дэвшүүлэх, саналаа солилцох, шаардлагатай мэдээллээр хангагдах эрхтэй.
- 4.2. Гэрээгээр тохирсон ажлын хөлсийг авах эрхтэй.
- 4.3. ....

*Үргэлжлэл бий .... /Зх/*